

2009 оны 1 дүгээр
сарын 7-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г хавсралтын ёсоор баталсугай.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг оны эхнээс эрчимтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг оновчтой хуваарилан, үр дүнтэй ашиглах, төсвийн бус эх үүсвэрийг дайчлах талаар санаачилгатай ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

4. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг 2009 оны 10 дугаар сард, биелэлтийг 2010 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд С.Баярцогт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАЯР

Сангийн сайд

С.БАЯРЦОГТ

Хянасан:

Монгол Улсын сайд, Засгийн газрын
Хэрэг эрхлэх газрын дарга

Б.ДОЛГОР

Засгийн газрын 2009 оны 2 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт, арга хэмжээ	Хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт	2009 онд хүрэх түвшин	Хариуцан хэрэгжүүлэх Засгийн газрын гишүүн, албан тушаалтан
Нэг. Макро эдийн засгийн бодлого			
Зорилт 1. Инфляцийн хэт өсөлтийг бууруулж, макро эдийн засгийн тогтвортой, тэнцвэрт байдлыг хангах замаар бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ			
1.1. Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийг нэмэгдүүлэх	ДНБ-ний бодит өсөлт /хувиар/ нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ /ам.доллар/	10.1 2042.1	С.Баярцогт, Засгийн газрын гишүүд
1.2. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	С.Баярцогт
1.3. Төсөв, мөнгөний харилцан уялдсан бодлогыг хэрэгжүүлж, үнэ тарифын харьцангуй тогтвортой байдлыг хангах 1.3.1. Мөнгөний болон санхүүгийн бодлогын харилцан уялдааг хангах зорилгоор Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2008 оны 129/133 тоот хамтарсан тушаалаар баталсан “Сангийн яам, Монголбанкны хооронд мэдээлэл солилцох журам”-ыг мөрдөж ажиллах	хэрэглээний үнийн индекс /хувиар/ -	нэг оронтой тоонд байлгах -	С.Баярцогт, Л.Пүрэвдорж
1.4. Хүн амын хүнсний зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Бадамжунай
1.5. Экспортын орлогыг нэмэгдүүлж, гадаад худалдааны тэнцлийг сайжруулах	импортыг хангах хэмжээ /долоо хоногоор/ цэвэр албан нөөц /сая ам.доллар/	17.7 1272.5	С.Батболд, Л.Пүрэвдорж

1.6. Төсвийн орлого, зарлагын харьцааг зохистой түвшинд байлгаж, хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	ДНБ-д нэгдсэн төсвийн орлогын эзлэх хэмжээ /хувиар/ ДНБ-д нэгдсэн төсвийн зарлагын эзлэх хэмжээ /хувиар/ ДНБ-д урсгал төсвийн ашгийн эзлэх хэмжээ /хувиар/	34.3 40.4 4.6	С.Баярцогт
1.7. Үр ашиггүй зардлыг бууруулах замаар төсвийн алдагдлыг аль болохоор багасгах 1.7.1. Батлагдсан орон тоо бүтцээс гадуур шинээр орон тоо бий болгож санхүүжилт гаргахыг хязгаарлаж зохицуулалт хийх 1.7.2. Бүх төрлийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт болон бэлэн бус хэлбэрээр үзүүлж байгаа төрийн үйлчилгээг нэгтгэн авч үзэж давхардлыг арилгах, нийгмийн халамж зайлшгүй хүртэх шаардлагатай иргэдэд чиглүүлэх бодлого хэрэгжүүлэх	ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хэмжээ /хувиар/ - -	-6.1 - -	С.Баярцогт С.Баярцогт Т.Ганди, С.Баярцогт
1.8. Эдийн засаг, нийгмийн салбарт оруулах хөрөнгө оруулалтын арга хэмжээг эдийн засгийн боломжтой уялдуулан хэрэгжүүлэх	ДНБ-д хөрөнгийн зардлын эзлэх хэмжээ /хувиар/	8.7	С.Баярцогт
1.9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн бааз бий болгох, хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр боловсруулах	хөтөлбөр батлагдсан байх	-	С.Баярцогт
1.10. Мөнгө, санхүүгийн болон бодит эдийн засгийн бодлогын хоорондын уялдааг хангах, зохицуулахтай холбогдуулан эрх зүйн орчны шинэтгэлийг хийж, хэрэгжүүлэх	-	-	С.Баярцогт
1.11. Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллого явуулах бэлтгэлийг хангах хүрээнд хүн амын мэргэжил, албан тушаалын ангилал, боловсролын түвшний ангилал, код, ойлголтын тодорхойлолт зэргийг шинэчлэн боловсруулах	баримт бичиг бэлэн болсон байх	-	С.Мэндсайхан

Зорилт 2. Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн үнэлгээг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг эрчимжүүлнэ			
2.1. Тэтгэврийн сангийн бие даасан үйл ажиллагааг дэмжих замаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг урт хугацааны хөрөнгө оруулалтад ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх	хууль батлагдсан байх	-	Т.Ганди, С.Баярцогт
2.1.1. Төрөөс тэтгэврийг нь хариуцах иргэдийн тэтгэвэрт зориулан улсын төсвөөс олговол зохих хөрөнгийн тооцоог хийж, тодорхой хэсгийг тэтгэврийн даатгалын санд буцаан байршуулах, сангийн бие даасан байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх	-	-	Т.Ганди, С.Баярцогт
2.1.2. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Нийгмийн даатгалын “хуримтлалын сан”-д төвлөрүүлэх хөрөнгийг урт хугацааны хөрөнгө оруулалтад оруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх	-	-	Т.Ганди, С.Баярцогт
2.2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн зарим хэсгийг Засгийн газрын үнэт цаас хэлбэрээр гаргаж олон улсын санхүүгийн зах зээлд арилжаалж эхлэх, Хөгжлийн банк байгуулах	Хөгжлийн банк байгуулах	-	С.Баярцогт
2.2.1. Олон улсын санхүүгийн зах зээл дээр Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлж, УИХ-аар батлуулах	-	-	С.Баярцогт
2.2.2. Хөгжлийн банк байгуулах тухай хуулийг батлуулж, банк байгуулах ажлыг зохион байгуулах	-	-	С.Баярцогт, Л.Пүрэвдорж
2.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг олон улсын санхүүгийн зах зээлийн нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгож, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	С.Баярцогт, Д.Баярсайхан
2.4. Үнэт цаасны зах зээлийг өргөжүүлж, үнэт цаасны төлбөр тооцооны төвийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Д.Баярсайхан
2.5. Урт хугацааны зээл, ипотекийн аргыг нэвтрүүлэх замаар залуу гэр бүл, бага орлоготой иргэдийг орон сууцаар хангах орон сууцны зээлийн бодлого хэрэгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга
2.6. Банк, санхүүгийн системийн тогтвортой үйл ажиллагааг хангах, эдийн засгийн өсөлт, бодит салбарын хөгжлийг дэмжсэн бодлогыг Монголбанктай хамтран хэрэгжүүлэх	хөрөнгийн хэмжээ /тэрбум ам.доллар/	3.0 хүртэл	С.Баярцогт, Л.Пүрэвдорж
2.7. Банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлж, монополь байдлыг арилгах, энэ бодлогын хүрээнд төрөөс олгож буй цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг иргэдэд хүргэх үйлчилгээг арилжааны банкуудын дунд тендер зарлаж сонгон шалгаруулах зарчмыг хэрэгжүүлэх	-	-	С.Баярцогт

2.8. Иргэдийн хадгаламжийг даатгах эрх зүйн орчныг бий болгох	-	-	С.Баярцогт, Л.Пүрэвдорж, Ц.Нямдорж
2.9. Хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагааг боловсронгуй болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	С.Баярцогт
2.9.1. Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, мэргэжлийн нягтлан бодогч, аудитор, эрдэмтдийн санал авах	-	-	
2.9.2. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран аудитын компаниудад чанарын хяналтыг хэрэгжүүлэх	-	-	
2.10. Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг сайжруулах	Хөрөнгийн үнэлгээний тухай хууль батлагдсан байх	-	С.Баярцогт
2.11. Засгийн газрын худалдан авах ажиллагааг олон нийтэд ил тод болгох хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах бэлтгэлийг хангах, энэ тухай бүх мэдээллийг цахим хуудсаар мэдээлэх ажлыг эрчимжүүлэх	цахим хэлбэрт шилжүүлж эхлэх	-	С.Баярцогт
2.11.1. Засгийн газрын худалдан авах ажиллагааны удирдлага, төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээг сайжруулах, мэдээллийн систем, мэдээллийн санг бий болгох	-	-	С.Баярцогт
2.11.2. Засгийн газрын байгууллага болон хувийн хэвшил хооронд тендерийн баримт бичгийг онлайнаар солилцох болон e-Shopping mall-ыг нэвтрүүлэх ажлыг судлах	-	-	С.Баярцогт
Хоёр. Бодит салбарын хөгжлийн бодлого			
Зорилт 3. Хувийн хэвшил, бизнесийн хөгжлийг дэмжсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, байгаль экологид ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ			
3.1. Засгийн газар, хувийн хэвшлийн зөвлөлдөх тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжүүлэх механизмыг нь бий болгож мөрдүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Б.Долгор
3.1.1. Засгийн газар, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх эрх зүйн үндсийг Улсын Их Хурлаар батлуулан мөрдөх	-	-	
3.1.2. Засгийн газар, хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлүүдийг тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүлэх	-	-	

3.2. Төр болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулан, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог боловсронгуй болгох, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан объектуудыг тодорхой хугацаагаар ашиглуулсны дараа төрд шилжүүлж өгөх үйл ажиллагааг дэмжих	-	-	С.Баярцогт
3.3. Үндэсний стандартуудыг олон улсын стандартын түвшинд ойртуулах, хүргэх замаар хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Н.Алтанхуяг
3.4. Оюутолгойн зэс-алтны уурхайг барьж эхлэх, Тавантолгойн нүүрсийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	Хөрөнгө оруулалтын гэрээ батлагдсан байх	-	Д.Зоригт
3.4.1. Оюутолгойн зэс алтны орд газрыг ашиглах гэрээг хөрөнгө оруулагчтай байгуулж уг гэрээг Улсын Их Хурлаар батлуулах, хөрөнгө оруулалтын ажлыг эхлүүлэх	-	-	Д.Зоригт, С.Баярцогт
3.4.2. Тавантолгойн нүүрсийг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг сонирхогч талуудтай хамтран байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээг Улсын Их Хурлаар батлуулах	-	-	Д.Зоригт, С.Баярцогт
3.5. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийг түшиглэн зэсийн баяжмалыг хайлуулах, цэвэршүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг барьж эхлүүлэх	-	-	Д.Зоригт
3.6. Баянгол, Төмөртэйн төмрийн хүдрийн ордыг ашиглах	жилд олборлох төмрийн хүдэр /сая тонн/	2.6	Д.Зоригт
3.7. Худалдааны тухай болон биржийн худалдааны үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг бий болгож мөрдүүлэх	хууль батлагдсан байх	Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний биржийн тогтолцоо бүрдсэн байна	Т.Бадамжунай
3.7.1. Биржийн тухай хуулийг батлуулж, эхний ээлжинд мах, арьс шир зэрэг бүтээгдэхүүн, түүхий эдийн төрөлжсөн биржүүдийг зохион байгуулах	-	-	
3.8. Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн урт хугацааны бага хүүтэй зээлийн тааламжтай нөхцөлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Н.Алтанхуяг

3.9. Шинэ үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлж эхлэх, бүсийн тулгуур төвүүд болон зарим орон нутагт үйлдвэр-технологийн парк, технологи дамжуулах төв байгуулах, тэргүүний технологийг нэвтрүүлэх чиглэлээр ажиллах	байгуулж эхлэх паркийн тоо	1-2	Н.Алтанхуяг
3.10. Үйлдвэржилт, жижиг, дунд үйлдвэрлэл болон ажил эрхлэлтийг дэмжихэд зориулж улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан, гадаадын зээл, тусламж, хувь хүний орлогын албан татварын орлого зэрэг эх үүсвэрүүдээс 150.0 тэрбумаас доошгүй төгрөгийн хөрөнгө гаргах ажлыг эхлүүлэх	нийт эх үүсвэр, /тэрбум төгрөгөөр/	150-иас доошгүй	С.Баярцогт, Т.Бадамжунай
3.11. Аймаг, нийслэлд “Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сан”-г байгуулж, жижиг, дунд бизнесийг дэмжих	-	-	Т.Бадамжунай
3.12. Боловсруулах үйлдвэрийн Монгол брэндийг бий болгож, ноолуур, арьс, ширэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хонь болон тэмээний ноос зэрэг түүхий эдийн үнийг өсгөх арга хэмжээ авах 3.12.1. Нарийн, нарийвтар ноост хонь өсгөх ажлыг зохион байгуулах	- -	- 3 хүртэл бүдүүвтэр, нарийн, нарийвтар ноосны сүргийн тоог өсгөнө	Т.Бадамжунай
3.13. “Чацаргана” төслийг боловсруулж хэрэгжүүлэх, энэ төслийн хүрээнд улсын хэмжээнд эхний ээлжинд 20 мянган гектар талбайд чацаргана тариалж, боловсруулах үйлдвэрүүдийг барих ажлыг эхлүүлэх	чацаргана тариалж эхлэх талбайн хэмжээ /мянган гектар/	20.0	Т.Бадамжунай
3.14. Хог хаягдлыг ашиглан үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг дэмжиж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Л.Гансүх
3.15. Уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжиж, стратегийн ордуудыг зүй зохистой ашиглах нэгдсэн бодлого боловсруулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Ашигт малтмалын тухай хуулийг батлуулах	-	Д.Зоригт
3.16. Дархан-Уул аймагт газрын тос боловсруулах үйлдвэрийг бэлэн болсон техник, эдийн засгийн үндэслэлийн үндсэн дээр барьж эхлэх	барилгын ажил эхэлсэн байх	-	Д.Зоригт
3.17. Автобензин, дизелийн түлшийг 3 сарын нөөцтэй болгох арга хэмжээ авах	-	-	Д.Зоригт

Зорилт 4. Эдийн засгийн өндөр өсөлтийг хангахад шаардагдах эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчим хүчний салбарт шинэчлэл хийж, найдвартай ажиллагааг хангана			
4.1. Улаанбаатар хотод дулаан, цахилгааны 5 дугаар станцыг шинээр барих ажлыг эхлүүлэх	хүчин чадал	400 мВт	Д.Зоригт
4.2. Улаанбаатар-Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн 220 кВт цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө, авто замыг барьж эхлэх	цахилгаан дамжуулах шугамын урт /км/	429	Д.Зоригт
4.3. Сумын төв болон малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах	хамрагдах сумын тоо	4	Д.Зоригт
4.3.1. Багийн төвүүдийн цахилгаан хангамжийн судалгаа хийх	малчин өрхийн тоо -	8000 -	
4.4. Дөргөн болон Тайширын усан цахилгаан станцыг ашиглалтад оруулах	хүчин чадлаараа ажиллаж эхлэх	-	Д.Зоригт
4.5. Нүүрс, шатдаг занар, биомасс зэрэг түүхий эдээс шингэн түлш гарган авах технологийг турших ажлыг эхлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Д.Зоригт
4.5.1. Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн туршилт, судалгааны ажлыг хувийн хөрөнгө оруулагчдын оролцоотойгоор зохион байгуулах	-	-	Д.Зоригт
4.5.2. Нүүрс шингэрүүлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хувийн хөрөнгө оруулалтыг татах, дэмжихэд чиглэсэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	-	-	Д.Зоригт, Ц.Нямдорж
4.5.3. Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангах	-	-	Д.Зоригт
4.6. Улаанбаатар хотод “Дулааны цахилгаан станц-2”-ыг түшиглүүлэн коксжсон түлшний үйлдвэр барих ажлыг үргэлжлүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Д.Зоригт
4.6.1. Улаанбаатар хотод “Дулааны цахилгаан станц-2”-ыг түшиглэн коксжсон түлшний үйлдвэр байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлыг эхлүүлэх	-	Сонгон шалгаруулалт хийж, гэрээ байгуулсан байна	
4.7. Эрчим хүч экспортлох зорилгоор Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан станц барьж эхлэх	-	-	Д.Зоригт
4.7.1. Шивээ-Овоогийн станцын талаар БНХАУ-ын талтай яриа хэлцлийг эцэслэн тохирох	-	-	

4.7.2. Нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг эхлүүлэх, станц барих ажлыг эхлүүлэх	-	-	
Зорилт 5. Хүн амыг эрүүл хүнсээр бүрэн хангах зорилгоор мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах бодлого баримтална			
5.1. Хүнсний бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах чиглэлээр гадаад түншүүдтэй нягт хамтран ажиллаж, энэ чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Бадамжунай
5.1.1. Төв, суурин газрын хүн амын махны хангамжийг сайжруулах, үнийн хэт өсөлтөөс сэргийлэх зорилгоор “Махны нөөцийн сан” бүрдүүлэх, хангамж, нийлүүлэлтийг зохион байгуулах	-	-	
5.1.2. Бараа, түүхий эдийн нөөцөд тулгуурласан удаан хугацаанд хадгалагдах сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгжид зээлийн дэмжлэг үзүүлэх	үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүн /сая литр/	130.0	
5.1.3. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд техникийн зохицуулалт хийх	-	-	
5.1.4. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эрх зүйн зохицуулалтыг боловсруулж шийдвэрлүүлэх	-	-	
5.1.5. Хүн амын ургамлын тосны хэрэгцээний 30-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах	үйлдвэрлэх тосны хэмжээ /мян.тн/	5.0	
5.1.6. Өндөгний хангамжийг сайжруулж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Дотоодын өндөг үйлдвэрлэлийн хэмжээ /сая ширхэг/	50.0	
5.2. Хүнс, хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулах биржийн сүлжээ бий болгох	бирж байгуулах	-	Т.Бадамжунай
5.3. Өрхийн аж ахуйгаас бэлтгэсэн илүүдэл төмс, хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ борлуулах, татвар, түрээсийн төлбөргүй хүнсний зах, салбар, цэгүүдийг аймаг, сумын төв, нийслэлийн дүүрэг, хороодод байгуулж ажиллуулах	хүнсний зах, цэгүүд ажиллаж эхлэх	-	Т.Бадамжунай, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
5.4. Нийслэл болон орон нутгийн томоохон хотуудад экологийн цэвэр сүү, цагаан идээ, мал болон гахай, тахианы мах, махан бүтээгдэхүүн, өндөгний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, “Сүү” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх	-	-	Т.Бадамжунай, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар

5.5. Жимс, жимсгэний аж ахуйг хөгжүүлэх хөрөнгийг шийдвэрлүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх	-	-	Т.Бадамжунай
5.6. Бүс нутгийн онцлогийг харгалзан малчдад бэлчээрийг гэрээгээр эзэмшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээр, усны нөөцийг зохистой ашиглах бодлого баримтлах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Бадамжунай
5.7. Тариалан эрхлэгч компани болон малчдад бага оврын трактор, хөрс боловсруулах техник хэрэгслийг хөнгөлөлттэй үнээр болон том, дунд оврын техникийг лизингээр нийлүүлэх	тракторын тоо	3000	Т.Бадамжунай
5.8. Малын чанарыг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулж, шилмэл үүлдрийн мал, омгийг бүртгэлжүүлж, цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагааг дэмжих	цөм сүргийн тоо /мянган толгой/	1100	Т.Бадамжунай
5.9. Мал аж ахуйн салбарт хөдөлмөрөө хорших, хөрөнгө хүчээ нэгтгэх, хоршоо, нөхөрлөл, бүлэг болон зохион байгуулагдаж ажиллахыг зээл, татварын бодлогоор дэмжих	-	-	Т.Бадамжунай
5.10. Малын угаалга, туулгалт, вакцинжуулалт зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрөөс хариуцан санхүүжүүлэх ажлыг эхлүүлэх	-	-	Т.Бадамжунай
5.11. Махны нийлүүлэлтийг тогтвортой байлгах зорилгоор үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааг дэмжих	үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ /мян.тн/	19 –өөс доошгүй	Т.Бадамжунай
5.12. “Атрын гурав дахь аян”-ы хэрэгжилтийг эрчимжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дотоодын үйлдвэрлэлийн улаан буудай, төмс, хүнсний ногооны хангамжийг дээшлүүлэх	дотоодын үйлдвэрлэлээр хангах гурилын хангалтын хувь	60.0	Т.Бадамжунай
	үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ /сая литр/	18.0	
	дотоодын тариалсан төмсний хангалтын хувь	100	
	дотоодын хүнсний ногооны хангалтын хувь	60.0-аас доошгүй	

5.13. Хөрсний эвдрэлтэй тэмцэх шинэ технологийн дагуу атаршсан талбайг тариалангийн зориулалтаар сэргээн ашиглах ажлыг эрчимжүүлэх	-	-	
5.13.1. Сэргээн ашиглах атаршсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх	Сэргээн ашигласан, атаршсан талбайн хэмжээ /мян.га/	80.0	Т.Бадамжунай
5.14. Иргэдийн оролцоотойгоор хөв, цөөрөм байгуулах, гар худаг гаргах үйл ажиллагааг дэмжиж, бэлчээрийн худаг, уст цэгт шинэчлэл хийх ажлыг эрчимжүүлэх	шинээр гаргах худгийн тоо	1000 –аас доошгүй	Т.Бадамжунай
5.15. Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, мэргэжилтэй малчин бэлтгэх ажлыг эхлүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Бадамжунай, Ё.Отгонбаяр
5.15.1. Мал аж ахуйн ажилтан бэлтгэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх	-	-	
5.16. Байгалийн гамшгийн улмаас малгүй болсон иргэдийг малжуулах төсөлд хамруулах	-	-	Т.Бадамжунай
5.17. Улаан буудайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор үнийн урамшууллыг үргэлжлүүлэх	буудайн хэмжээ /мян.тн/	142.0	Т.Бадамжунай
5.18. Ирэх оны гурилын үйлдвэрлэлд шаардагдах улаан буудайн дөрөвний нэгээс доошгүй хэсгийг худалдан авах замаар нөөц бүрдүүлэх	нөөц бүрдүүлэх улаан буудайн хэмжээ /мян. тн/	100.0	Т.Бадамжунай
5.19. Бэлчээр, тариалангийн талбайн хортон мэрэгч, шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулах	энгийн болон биологи, химийн аргаар тэмцэх талбай /мян.га/	800.0	Т.Бадамжунай
5.20. Мал аж ахуйг эрчимжүүлэх ажлын хүрээнд малын тэжээлийн үйлдвэрийг сэргээн хөгжүүлэх арга хэмжээ авах	хураан авах тэжээл /мян.тн/	15.0-аас доошгүй	Т.Бадамжунай
5.21. Малын эм бэлдмэлийг дотоодын үйлдвэрлэлээр хангах арга хэмжээг дэмжиж, мал амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	малын халдварт өвчний бууралт /хувь/	30	Т.Бадамжунай
5.22. Хүнс, тэжээлийн ихээхэн ач холбогдолтой ашигт ургамлыг тарималжуулах, түүний нэр төрлийг олшруулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Бадамжунай
5.23. Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийх, усалгаатай газар тариаланг өргөжүүлэх	усалгаатай нөхцөлд тариалах талбайн хэмжээ /мян.га/	43.0	Т.Бадамжунай

5.24. Услалтын систем засварлах, шинээр барихад зориулж улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	-	-	Т.Бадамжунай
5.25. Монгол орны нөхцөлд тохирсон таримлын сортуудыг бий болгох, үр үржүүлгийн бүсчилсэн аж ахуйг сэргээх, үрийн нөөц сантай болох зохистой арга замыг тогтоох, энэ чиглэлээр тодорхой ажлыг хийж эхлэх	-	-	Т.Бадамжунай
5.26. Өвөлжөө бууцны ойролцоох бэлчээрийг хашиж хамгаалах асуудлыг дэмжиж, улсын мэдлийн отрын бүс нутаг бий болгох	-	-	Т.Бадамжунай
5.26.1. Отрын бүс нутаг шинээр бий болгох зохион байгуулалтын арга хэмжээ авах	отрын бүс нутгийн тоо	3-аас доошгүй	
Зорилт 6. Барилга, хот байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж, иргэдийн оролцоотойгоор орон сууцны хороолол шинээр бий болгох ажлыг эхлүүлнэ			
6.1. Улаанбаатар хотын гэр хорооллуудыг дахин төлөвлөлт хийх замаар орон сууцны хороолол болгох ажлыг эхлүүлэх	шинээр баригдаж эхлэх хорооллын тоо	6	
6.1.1. “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн нэгдүгээр үе шатанд баригдах “Орон сууцны XIY хороолол”, “Орон сууцны YII хороолол”, “MYOHPT орчмын хороолол”-ын инженерийн дэд бүтцийг барьж, барилгажилтын ажлыг эрчимжүүлэх	-	-	Х.Баттулга
6.1.2. “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хоёрдугаар үе шатанд баригдах “YII бичил хороолол”, “Дарь-Эх хороолол”, “Дэнжийн 1000 хороолол”-ын инженерийн дэд бүтцийг барьж, барилгажилтын ажлыг эрчимжүүлэх	-	-	
6.2. Хот болон аймгийн төвүүдийн гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах төслийг боловсруулж, гэр хорооллын доторхи зам, цэвэр усны шугам, гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж эхлэх	-	-	Х.Баттулга
6.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан орон сууцаар хангах ажлыг үргэлжлүүлэх, “Орон сууц” үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг эхлэх	шинээр ашиглалтад орох орон сууцны тоо	9850	Х.Баттулга
6.4. Орон сууц барих санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон сууцны урт хугацаатай зээлийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн тогтолцоог бий болгон орон сууцны урт хугацааны зээлийн жилийн хүүг бууруулж, эргэн төлөгдөх хугацааг 25 жил болгох	-	-	Х.Баттулга
6.5. Хөшигийн хөндийд баригдах олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн байгуулах хотын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж эхлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	

6.5.1. Хот байгуулах газар нутгийн инженер-геологийн судалгааны үндсэн дээр хотын байршил, эдэлбэр газрын хэмжээг тогтоох	-	-	Х.Баттулга
6.5.2. Хот байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлэх	-	-	
6.6. Стратегийн болон бусад томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулахтай холбогдуулан Тавантолгой, Оюутолгой орчмын нутагт шинээр байгуулагдах хот, суурингийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга
6.6.1. Шинэ хот байгуулах газар нутгийн инженер-геологийн судалгааны үндсэн дээр хотын байршил, эдэлбэр газрын хэмжээг тогтоох	-	-	
6.6.2. Шинэ хот байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлэх	-	-	
6.7. Хот төлөвлөлт, барилгын зураг төсөл боловсруулах, инженерийн хайгуул, судалгаа хийх аж ахуйн нэгж, байгууллагуудын бүтцийг боловсронгуй болгож, чадавхийг дээшлүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга
6.8. Орон нутгийн эрдэс түүхий эдийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Хөтөлийн цементийн үйлдвэрт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	цементийн үйлдвэрлэлийн хүчин чадал /сая тн/	1.0	Х.Баттулга
6.9. Бүсийн тулгуур төв болон хилийн томоохон боомтуудад барилгын материалын чанарын лабораторийг байгуулж, ажиллуулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга
6.10. Шинээр баригдаж эхлэх хорооллын бэлтгэл ажлыг хангах хүрээнд хот, суурин газрын инженерийн шугам сүлжээг сайжруулах	Буянт-Ухаад шинээр баригдах орон сууцны хорооллын төвлөрсөн дулааны шугамд холбогдох өрхийн тоо өргөтгөн шинэчлэх бохир усны шугамын хоолойн урт /метр/	9000 1600	Х.Баттулга

Зорилт 7. Зам, тээвэр, харилцаа холбоо нь эдийн засгийн хөгжил, хүн амын амьдралын чухал нөхцөл тул дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд анхаарлаа илүү хандуулна			
7.1. Азийн авто замын сүлжээний АН-32, АН-4, АН-3 чиглэлийн болон Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгийн авто замын ажлыг эрчимжүүлэх	-	-	
7.1.1. Чойр–Замын-Үүд, Булган-Үенчийн чиглэлийн зам барих ажлыг үргэлжүүлэх	ашиглалтад орох авто замын урт/ км/	432	Х.Баттулга
7.1.2. Баян-Өлгий –Ховдын чиглэлд хатуу хучилттай зам барих	барих замын урт /км/	15	
7.1.3. Өндөрхаан-Сүмбэр, Тэрхийн гүүр-Их-Уул, Баянхонгор-Нарийнтээл, Арвайхээр-Баянхонгор, Хануйн гүүр-Халзан бүргэдэй-Тэрхийн гүүр, Өлгий-Цагааннуур, Дашинчилэн-Орхоны гүүр, Хөшөөцайдам-Өгий нуур чиглэлийн замуудыг үргэлжлүүлэн барих	ашиглалтад орох автозамын урт /км/	374	
7.2. Босоо тэнхлэгийн замын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	-	-	
7.2.1. “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд баригдах NP-2 багцын 62.2 км замын Замын-Үүд чиглэлийн 62 км замыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих	-	-	Х.Баттулга
7.2.2. “Баруун бүсийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн Манхан-Ховд, Ховд-Хашаатын даваа чиглэлийн 195.9 км, Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 32.5 км замыг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр барих асуудлыг шийдвэрлэх	-	-	
7.3. Авто зам, гүүрийн барилга байгууламжийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр барих ажлыг дэмжих	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга
7.3.1. Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 100 км, Яармагийн гүүр-Баянзүрхийн товчоо чиглэлийн 17 км, Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 107 км, Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн 200 км, Даланзадгад-Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 251 км зам барих	-	-	Х.Баттулга, С.Баярцогт
7.3.2. Улаанбаатар хотын Саппорогийн аюулгүйн тойргийн 2 түвшний уулзварын ажлыг эргэн төлөгдөх нөхцөлтэй хувийн хэвшлийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх	-	-	Х.Баттулга, С.Баярцогт
7.4. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах, тээврийн хэрэгслээс хүрээлэн буй орчин, хүн ам, замын хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга
7.4.1. Нийтийн зорчигч тээврийн том оврын автобусыг шинэчлэх	автобусны тоо	400	

Зорилт 8. Бүх төрлийн тээврийн хөгжил эрчимжих нөхцөлийг бүрдүүлж, аялал жуулчлалын салбарыг хөгжлийн нэг томоохон гарц гэж үзэж түлхүү хөгжүүлнэ			
8.1. Улсын чанартай болон хот хоорондын гол замуудын дагуу 100-150 км тутамд үйлчилгээний тохилог цогцолбор барих хөтөлбөр, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төслийг боловсруулж, хөтөлбөр, төслийг эхлүүлэх, замын засвар, арчлалтыг тогтмолжуулж, тэмдэгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	
8.1.1. Замын-Үүд боомтод автовокзал, үйлчилгээний цогцолбор барих зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх	-	-	Х.Баттулга
8.1.2. Дорноговь аймагт автовокзал, үйлчилгээний цогцолбор барих зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх	-	-	
8.1.3. Дархан-Уул аймагт автовокзал, үйлчилгээний цогцолбор барих зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх	-	-	
8.2. Говийн болон зүүн бүсийн төмөр замын сүлжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах	техник эдийн засгийн үндэслэл боловсрогдсон байх	-	Х.Баттулга
8.3. Улаанбаатар төмөр замын техник, технологийг шинэчилж, тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, Мянганы сорилтын сангийн Төмөр замын тээврийг сэргээх төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	төслийн ажил эхэлсэн байх	-	Х.Баттулга
8.3.1. Хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх	-	-	
8.3.2. Замын-Үүд, Сүхбаатар, Толгойт болон бусад өртөөнүүдийн ачаа боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж эхлэх	-	-	
8.4. Төмөр замын хос шугам барих асуудлыг судалж, хэрэгжүүлж эхлэх	-	-	Х.Баттулга
8.5. Төв аймгийн Хөшигийн хөндийд олон улсын нисэх буудлын дэд бүтэц барих ажлыг эхлүүлэх	барилгын ажил эхэлсэн байх	-	Х.Баттулга
8.5.1. Дулаан, усан хангамжийг шийдвэрлэж, Улаанбаатар хотоос 110 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж, дэд станцыг байгуулах	-	-	
8.5.2. Төв аймгийн Зуунмод хотоос шилэн кабель татаж, дамжуулах төхөөрөмжийг байгуулах	-	-	
8.6. Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг шинэчлэн мөрдүүлэх, байгаль орчинд халгүй аяллын төрлийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулан, жуулчин хүлээн авах болон дамжин өнгөрөх хүчин чадлыг нэмэгдүүлэх	жуулчин хүлээн авах хүчин чадлын нэмэгдэх хувь хүлээн авах жуулчдын тоо /мянга/	4.0 500.0	Л.Гансүх

8.6.1. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг голлох тусгай хамгаалалттай газар нутгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	-	-	Л.Гансүх
8.6.2. Аялал жуулчлалын маркетингийн стратеги төлөвлөгөө боловсруулах	-	-	
8.6.3. Аялал жуулчлалын стандартыг боловсронгуй болгох	-	-	
8.7. Аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулсан төрийн өмчит улсын үйлдвэрийн газар байгуулах	-	-	Л.Гансүх
8.7.1. Хөвсгөл нуур орчим аялал жуулчлалын дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг дэмжих	-	-	
8.8. Аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд Хөвсгөл нуурт усан замын тээврийн хэрэгсэл зорчих чиглэл, маршрутыг тогтоож, тэмдэгжүүлэх, тээврийн хэрэгслийн тусгай зогсоол барих	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Л.Гансүх
8.9. Өсөн нэмэгдэж буй тээврийн үйл ажиллагааг зохицуулах ажлын хүрээнд Замын-Үүдийн боомтын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга
8.10. Увс, Баян-Өлгий аймгийн нисэх онгоцны буудлын хатуу хучилттай зурвас барих ажлыг үргэлжлүүлэн, Завхан, Говь-Алтай аймгийн нисэх буудлын хатуу хучилттай зурвасыг барьж, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын онгоц хөөрч буух зурвасыг хүчитгэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга
8.11. Ховд аймгийн Булган сумын нисэх онгоцны буудлын зурвасыг хатуу хучилттай болгох ажлыг эхлүүлэх	-	-	Х.Баттулга
8.12. Хөвсгөл аймгийн Хатгалын нисэх онгоцны буудалд хатуу хучилттай зурвас барих, нислэг хөдөлгөөний бодит ажиглалтын систем, газрын навигацын тоног, төхөөрөмжийн шинэчлэлт хийх	-	-	Х.Баттулга
Зорилт 9. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг өргөжүүлж, иргэн бүрт хүртээмжтэй болгоно			
9.1. Айл өрх бүрийг интернэтийн хэрэглэгч болгох, малчид гар утас ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, шилэн кабельд холбогдсон сумдад электрон шуудангийн үйлчилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ж.Сансар
9.2. Шуудангийн үйл ажиллагаанд мэдээллийн технологид суурилсан үйлчилгээ нэвтрүүлж, шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ж.Сансар
9.3. Шуудангийн хаяг, кодын нэгдсэн системийг олон улсын түвшинд нийцэхүйцээр сайжруулан төгөлдөржүүлж, электрон шуудангийн үйлчилгээ, цахим худалдааг нэвтрүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ж.Сансар

Гурав. Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого			
Зорилт 10. Байгалийн нөөц баялгийн менежментийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгон, байгаль орчныг хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ			
10.1. Байгалийн нөөц баялгийг тогтвортой ашиглах, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх, хамгаалах урт хугацааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх, байгаль орчинд халгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих, хэрэгжилтэд хяналт тавих	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	
10.1.1. Байгаль орчны салбарын урт хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулах	-	-	
10.1.2. Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах төрийн бодлогыг тодорхойлох “Ус” үндэсний хөтөлбөрийг боловсруулах	-	-	Л.Гансүх
10.1.3. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах	-	-	
10.1.4. Баданга хүдэр хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах	-	-	
10.1.5. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах	-	-	
10.2. Байгалийн нөөцийг үр нөлөөтэй ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, стратегийн удирдлагын чадварыг бэхжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	
10.2.1. Ойн экосистемд сөрөг нөлөөтэй арга технологи ашиглахыг хязгаарлах, ойн нөөцийн ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх эдийн засгийн хөшүүргийг боловсронгуй болгох	-	-	Л.Гансүх
10.2.2. Зарим зүйл ан амьтны экологи- эдийн засгийн үнэлгээг шинэчлэн боловсруулж, батлуулах, хохирол тооцох аргачлал боловсруулах	-	-	
10.2.3. Усны нөөцийг хэмнэлттэй ашиглах, эргүүлэн ашиглах, бохир усыг цэвэршүүлэх техник, технологийг дэмжих эдийн засгийн урамшууллын системийг боловсронгуй болгох	-	-	
10.3. Мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэн ой бүхий талбайг эзэмшүүлэх үндсэн дээр ойг нөхөн сэргээж, хамгаалах менежментийг бүрдүүлэх	нөхөрлөл, аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн ойн сангийн эзлэх хувь	10.0	Л.Гансүх
10.3.1. Ойн санг нөхөрлөл, аж ахуйн нэгжид гэрээгээр эзэмшүүлэх журмыг боловсруулан мөрдүүлэх	-	-	

<p>10.4. Ойжуулалт, мод үржүүлгийн ажлын чанарыг дээшлүүлэх, хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх</p> <p>10.4.1. Нэн тэргүүнд ойжуулах, нөхөн сэргээх шаардлагатай газруудыг тодорхойлж, нийтэд зарлан 10000 га-д ойжуулалтын ажил хийх</p> <p>10.4.2. Ойн үрийн аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</p> <p>10.4.3. Хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэхэд орон нутаг дахь ойн байгууллага нутгийн иргэд, нөхөрлөлийн оролцоог нэмэгдүүлэх</p> <p>10.4.4. Хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэхэд орчин үеийн арга технологийг хэрэглэх туршилт, судалгааны ажлыг хийх</p>	<p>ойжуулалтын хэмжээ /мян.га/</p> <p>үрийн нөөц /кг/</p> <p>тарьц суулгацны тоо /мянган ширхэг/</p> <p>ногоон хэрэмний зурвас /га/</p> <p>ой зохион байгуулалт /мян.га/</p>	<p>12</p> <p>300</p> <p>5</p> <p>500</p> <p>19</p>	<p>Л.Гансүх</p>
<p>10.5. Ойн цэвэрлэгээ хийх замаар түймэрт шатсан болон өмхөрч, өгөршсөн унанги модыг цэвэрлэж түлшинд хэрэглэдэг тогтолцоог бий болгох</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Л.Гансүх</p>
<p>10.6. Голуудын сав газрын менежментийн зөвлөлийг байгуулах, зарим голын эхийг тусгай хамгаалалтад авах</p> <p>10.6.1. Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоож, дэглэмийг мөрдүүлэх</p> <p>10.6.2. Сав газрын зөвлөлийг байгуулж усны сав газрын хамгаалалтад орон нутгийн хүлээх үүрэг, хариуцлагыг боловсронгуй болгох</p> <p>10.6.3. Зарим голын сав газрыг хамгаалалтад авах асуудлыг шийдвэрлүүлэх</p>	<p>тусгай хамгаалалтад хамрагдах голын эхийн тоо</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>6</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Л.Гансүх</p>

10.6.4. Гол мөрний сав газрын усны менежментийн 2-оос доошгүй жишиг төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхлэх	-	-	Л.Гансүх
10.7. Газрын доорхи усны мониторингийн судалгаа явуулах, усны хяналт-шинжилгээний сүлжээг бүрдүүлж, ажиллах	хяналт-шинжилгээний сүлжээ байгуулах тоо	25	Л.Гансүх
10.7.1. Газрын доорхи усны мониторинг хийх цэгийн байршил, тоог нарийвчлан тогтоох	-	-	
10.7.2. Газрын доорхи усны эрэл хайгуул судалгааны ажлын норм, нормативыг шинэчлэн боловсруулах	-	-	
10.8. Бүсүүдийн тулгуур төв болон хот, суурин газрын усан хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуул, судалгааны ажлыг явуулж, нөөцийн хэмжээг тогтоох	эрэл, хайгуул явуулах газрын тоо	7	Л.Гансүх
10.9. Ан амьтны тархац, нөөцийг тогтоож, хамгаалах менежментийг боловсронгуй болгох ажлын хүрээнд иргэд, аж ахуйн нэгжийн ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх санаачилгыг дэмжих	идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхөрлөлийн тоо	3	Л.Гансүх
10.10. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бэхжүүлэх, аялал жуулчлал хөгжүүлэх үйл ажиллагаанд иргэдийг өргөн оролцуулсан хамтын менежментийг боловсронгуй болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Л.Гансүх
10.10.1. Биологийн төрөл зүйлийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах, стратегийн арга хэмжээ авах	-	-	
10.10.2. Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын даац, нөөцийг тодорхойлох аргачлалыг боловсруулах ажлыг эхлүүлэх	-	-	
10.10.3. Дэлхийн шим мандлын дархан газрын сүлжээ, Рамсарын конвенц, дэлхийн байгалийн өвийн төвүүд болон бусад олон улсын байгууллагуудтай хэлхээ холбоог өргөжүүлэн, тусгай хамгаалалттай нутгийг хамгаалах талаар хамтран ажиллах	-	-	
Зорилт 11. Агаар, ус, хөрсний бохирдол, орчны доройтлыг бууруулах, хянах тогтолцоог боловсронгуй болгоно			
11.1. Бохирдуулагч нь төлбөр төлөх зарчмыг хэрэгжүүлж, агаарын чанарыг хангах арга хэмжээг санхүүжүүлэх оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	

11.1.1. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсний төлбөрийн тухай хуулийг эцэслэн боловсруулж Улсын Их Хурлаар батлуулан мөрдөх	-	-	Л.Гансүх
11.1.2. Агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний санхүүжилтийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгох	-	-	
11.2. Хүрээлэн буй орчны хяналт-шинжилгээ, судалгааны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, лабораторийн мэргэжлийн албаны чадавхийг бэхжүүлэх	нэмж байгуулах болон шинэчлэн тоногдсон лаборатори, нэгжийн тоо	2	Л.Гансүх
11.2.1. Гадаргын усны хяналт-шинжилгээний сүлжээний нэгж, усны шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсронгуй болгох	-	-	
11.3. Хяналт-шинжилгээ, судалгааны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар үнэлгээ хийх	агаар бохирдуулах эх үүсвэрийн хяналт-шинжилгээний лаборатори	1	Л.Гансүх
11.4. Газрын нэгдмэл сангийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгон газрыг үр ашигтай ашиглах, хамгаалах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Л.Гансүх
11.4.1. Газрын хөрс, ургамлан нөмрөгийн экологи эдийн засгийн үнэлгээг бүх үзүүлэлтээр боловсронгуй болгон газрын үнэ, төлбөрийг түүний хөрсний шинж чанарыг илтгэгч гол үзүүлэлтүүд, ашиглалтын зориулалттай уялдуулан байгалийн бүс бүслүүрээр төдийгүй хэсэг талбар газар бүрээр ялгавартай тогтоож мөрдүүлэх	-	-	
11.5. Газрын нэгдсэн төлөвлөгөөг Улсын Их Хурлаар батлуулж, нийслэл, аймгуудын төв болон төвлөрсөн суурингийн гэр хорооллыг барилгажуулахаас бусад газруудыг зөвхөн нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тогтолцоонд шилжих	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
11.5.1. Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах	-	Хуулийн төсөл боловсруулсан байна	Х.Баттулга
11.5.2. Төрийн өмчийн газрыг эзэмшүүлж, ашиглуулахтай холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулсан журмыг боловсруулж, батлах	-	Засгийн газрын тогтоол гарсан байна	

11.5.3. Газрын нэгдмэл сангийн тайлангийн өгөгдлүүдийг боловсронгуй болгох ба түүнд газрын ангиллын шилжилт, хөдөлгөөнийг байнга тусгах, байгаль орчны даац, чадавхид нийцүүлсэн газар зохион байгуулалтын урт хугацааны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	-	-	Х.Баттулга
11.6. GPS-ийн технологийг нэвтрүүлэн, Монгол Улсын GPS-ийн сүлжээ байгуулах 2 дахь шатны ажлыг хийж, өндрийн сүлжээг сайжруулах	зураглалын ажлын чанар сайжрах нөхцөл бүрдэнэ	-	Ж.Сансар
11.7. Говь, хээр, цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгуудад усны нөөцийг нэмэгдүүлэх, мод, бут сөөг тарьж ургуулах ажлыг эрчимжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Л.Гансүх, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
11.7.1. Говь хээрийн бүсэд усан сан, хөв байгуулах, мод бут сөөг тарьж ургуулах ажлын үр дүнг сайжруулан арчилгаа, хамгаалалтыг сайжруулах	-	-	
11.8. Говь, хээрийн цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд баянбүрд үүсгэх, худаг ус гаргах, усжуулах бүхий л санал, санаачилгыг дэмжиж, “Ус” хөтөлбөрийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх, хөдөөгийн баг бүрт сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан шинээр 1 худаг нэмж гаргах ажлыг эхлүүлэх	-	-	Л.Гансүх, Т.Бадамжунай, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
11.8.1. Усны нөөцийг бохирдол хомсдолоос хамгаалах “Ус” үндэсний хөтөлбөрийг боловсруулж усны салбарын урт хугацааны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох	-	-	Л.Гансүх
11.8.2. Газрын доорхи усны нөөцийн мониторингийн үр дүнд ус ашиглалтын дүгнэлт гарган, худаг гаргаж ашиглах боломжийг судлан тогтоох	-	-	Л.Гансүх, Т.Бадамжунай
11.9. Уул уурхайн үйлдвэрлэлийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шаардлагын хэрэгжилтэд тавих хяналтыг чангатгаснаар олборлолтод өртсөн эдэлбэр газрыг нөхөн сэргээх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	
11.9.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлал боловсруулж батлуулах	-	-	Л.Гансүх
11.9.2. Шинээр батлагдсан уул уурхайн нөхөн сэргээлтийн стандартууд, экологи-эдийн засгийн үнэлгээ хийх аргачлалыг туршиж боловсронгуй болгох, сургалт, мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах	-	-	
11.10. Алтны бага нөөцтэй шороон орд, усны хагалбар, голын ай сав газар, ойн сан, говийн баянбүрд, байгалийн онцгой тогтоц бүхий газрууд, түүний хамгаалалтын бүсэд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байдлыг үе шаттайгаар зогсоож эхлэх, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай технологиор уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг бүрэн зогсоох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Л.Гансүх, Д.Зоригт

11.10.1. Алтны бага нөөцтэй шороон орд, ой, усны сан бүхий газар, усан хангамжийн эх үүсвэрүүд, тэдгээрийн хамгаалалтын бүсэд ашигт малтмал олборлохыг хориглох тухай хуулийн төсөл боловсруулах талаар судалгаа хийх	-	-	Л.Гансүх, Д.Зоригт
11.11. Үйлдвэрлэл, үйлчилгээний менежментийг боловсронгуй болгож, хог хаягдлын хэмжээг багасгах, дахин ашиглах, томоохон хот, суурин газруудын хог хаягдлын зориулалтын төвлөрсөн цэгийг байгуулах, ландфиллийн аргыг нэвтрүүлэх 11.11.1. Хог хаягдлын хэмжээг багасгах зорилгоор ангилан ялгах эргүүлэн ашиглах системийг сайжруулах эрх зүйн болон эдийн засгийн хөшүүргийг боловсронгуй болгох 11.11.2. Хог хаягдлыг дахин боловсруулах байгаль орчинд халгүй арга технологийг хөгжүүлэх механизмыг сайжруулах 11.11.3. Орон нутагт ахуйн хог хаягдлын төвлөрсөн цэгийг байгуулж хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх	тохижуулах хог, хаягдлын төвлөрсөн цэгийн тоо - - -	1 - - -	Л.Гансүх
11.12. Хот, суурингийн хөрсний бохирдлын талаар нарийвчилсан судалгаа хийж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	сан байгуулагдсан байх	-	Л.Гансүх
11.13. Нүүрсийг хийжүүлэх, хагас кокс болгон боловсруулах, бүрэн шаталттай түлш хэрэглэдэг автомашин, нийтийн тээврийн хэрэгслийг дэмжих замаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг багасгах 11.13.1. Цэвэр түлш, коксон түлшний үйлдвэрлэлийг дэмжих болон нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг тодорхойлж, үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх 11.13.2. Нүүрсийг хийжүүлэн зарим халаалтын зууханд нэвтрүүлэх боломжийг судлах чиглэлээр тооцоо, судалгааны ажлыг хийх 11.13.3. Агаарын бохирдлыг багасгах салбар дундын зохицуулалтыг сайжруулан авто тээврийн хэрэгслийн хорт утааны стандартыг шинэчлэх 11.13.4. Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх механизм болон бусад арга хэрэгслийг хөгжүүлэх, тогтвортой хэрэглээний сонголтыг дэмжих усны нөөц болон эрчим хүчийг хэмнэх бүтээгдэхүүнийг урамшуулах бодлогыг хэрэгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр - - - -	- - - - -	Л.Гансүх, Д.Зоригт, Нийслэлийн Засаг дарга Л.Гансүх, Д.Зоригт Д.Зоригт Л.Гансүх Д.Зоригт

11.13.5. Авто тээврийн хэрэгслээс гарах хорт хийг бууруулах экологийн үнэлгээний стандарт, техникийн шаардлага боловсруулах, түлш шатахуунд агуулагдах хар тугалга, хүхэр зэрэг хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээг стандарт тогтоож мөрдүүлэх	-	-	Л.Гансүх
<p>11.14. Химийн хортой болон аюултай бодисын менежментийг сайжруулах, зориулалтын байгууламж бүхий төвлөрсөн цэг байгуулах бэлтгэлийг хангах</p> <p>11.14.1. Химийн хортой болон аюултай бодисын ангиллыг боловсронгуй болгон Засгийн газраар батлуулж мөрдүүлэх</p> <p>11.14.2. Аюултай хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Л.Гансүх, Нийслэлийн Засаг дарга</p> <p>Л.Гансүх</p>
<p>11.15. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чанар, үр дүнг нэмэгдүүлж, олон нийтийн хяналтын оролцоог өргөтгөх</p> <p>11.15.1. Олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон болон нөхөн сэргээлт хийсэн талбайн улсын хэмжээний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p>	Л.Гансүх
<p>11.16. Ус хэмнэх, бохир усыг цэвэршүүлэх техник, технологийн хөрөнгө оруулалтыг дэмжих</p> <p>11.16.1. Усны нөөцийг хэмнэлттэй ашиглах, бохир усыг цэвэршүүлэх техник, технологийн ашиглалтыг дэмжиж, гааль татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгох</p> <p>11.16.2. Аялал жуулчлалын бааз, гэр хороолол, хувийн орон сууцны бохир ус цэвэршүүлэлтийн түвшинд хяналт тавьж, бохир усыг цэвэршүүлэх бага оврын техник, технологийн хэрэглээг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	Л.Гансүх
<p>11.17. Уур амьсгалын өөрчлөлтийн таагүй нөлөөллийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, стратеги боловсруулан хэрэгжүүлэх</p> <p>11.17.1. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүн ам, мал аж ахуй, газар тариаланд нөлөөлөх нөлөөллийн эрсдлийн үнэлгээг бүс нутаг бүрээр гаргах</p> <p>11.17.2. Уур амьсгалын өөрчлөлтийн цаашдын хандлагыг тодорхойлж өөрчлөлтөд дасан зохицох бодлогыг үндэсний эрдэмтдийн багийн тусламжтайгаар боловсруулах</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	Л.Гансүх

11.18. Цаг агаарт зориудаар нөлөөлөх замаар хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах	хөдөлгөөнт багийн тоо газрын генератор	2 1	Л.Гансүх
11.18.1. Цөлжилт, гангийн эрсдлийг бууруулах, техник хэрэгсэл хүрэх боломжгүй ой хөвчид гарсан түймрийг унтраах зорилгоор нөхцөл бүрдсэн үед цаг агаарт зориудаар нөлөөлж тунадас нэмэгдүүлэх	-	-	
11.18.2. Үүлний судалгааны зориулалттай зөөврийн радар 1 ширхгийг орон нутагт суурилуулж ашиглалтад оруулах	-	-	
11.18.3. Газрын генераторыг орон нутагт суурилуулан ашиглах	-	-	
Зорилт 12. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжих, хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот, тосгоныг хөгжүүлнэ			
12.1. Орхон-Сэлэнгэ-Дарханы эрчимтэй хөгжлийн бүсийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүтцийг бүрдүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	М.Энхболд
12.2. Говийн бүс нутагт Оюутолгой, Таван толгой, Цагаан суваргын ашигт малтмалын нөөцийг цогцоор ашиглахад чиглэсэн экспортын үйлдвэрлэлийн бүс байгуулах, дэд бүтцийн үндсэн сүлжээ бүрдүүлж эхлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	М.Энхболд, Д.Зоригт
12.3. Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуурын чөлөөт бүсэд түшиглэн эдийн засаг, экспортын өсөлтийг дэмжих хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж эхлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	М.Энхболд
12.4. Улаанбаатар хотын хүн амын хэт ачааллыг багасгаж, дагуул хотууд болох Багануур, Налайх, Багахангайг хөгжүүлэх, тэдгээрт зохистой төвлөрлийг бий болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Х.Баттулга, Нийслэлийн Засаг дарга
12.4.1. Багануур, Налайх, Багахангай дүүргийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах	-	-	
12.5. Улаанбаатар хотыг шинэчлэн хөгжүүлэх “Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл” хөтөлбөр батлах, нийслэлд агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, дэд бүтэц, хогны асуудлыг иж бүрэн шийдвэрлэх, хот байгуулалт, хот төлөвлөлтийн бодлогыг шинэчлэн баталж, хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг дүүрэг бүрт байгуулах ажлыг эхлүүлэх	-	-	Х.Баттулга, Нийслэлийн Засаг дарга
12.5.1. Японы ЖАИКА байгууллагатай хамтран боловсруулж буй “Улаанбаатар хотын мастер төлөвлөгөө болон хот байгуулалтын судалгаа” төслийн ажлыг баталгаажуулж хэрэгжүүлж эхлэх	-	-	Х.Баттулга

12.5.2. Хот суурин газрын ногоон байгууламжийн норм нормативыг шинэчлэх	-	-	Л.Гансүх
12.6. Дорноговь аймгийн Замын-Үүдэд цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ, ус цэвэршүүлэх станц, цэвэрлэх байгууламж, дулааны станц барих ажлыг эхлүүлэх	барилгын ажил эхэлсэн байх	-	Х.Баттулга, Д.Зоригт
12.6.1. Дээрх ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хянаж гүйцэтгэлд мэргэжлийн хяналт тавих	-	-	Х.Баттулга, Д.Зоригт
Дөрөв. Ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангах бодлого			
Зорилт 13. Хүн амын хөгжлийг ханган, хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ			
13.1. Хүн амын өсөлтийг дэмжих хүрээнд хүүхдийн мөнгө, шинэ гэр бүл, шинэ хүүхэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Ганди, С.Баярцогт
13.1.1. Хүн амын өсөлтийг хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор 2009 онд 0-18 насны хүүхэд бүрт сар бүр олгох тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох	-	-	
13.1.2. 2009 онд шинээр төрсөн хүүхэд бүрт нэг удаа 100.0 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг олгох	-	-	Т.Ганди
13.1.3. 2009 онд шинээр гэр бүл болсон залуучуудад нэг удаа 500.0 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг олгох	-	-	
13.2. Стратегийн болон томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчин болон санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлж эхлэх	хууль батлагдаж, хувь хүртээх ажил эхэлсэн байх	-	Т.Ганди
13.3. Ашигт малтмалын салбарын хөгжлийг түргэтгэх эрх зүйн орчныг шинэчлэх, ашигт малтмалын стратегийн болон томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар хуримтлал бий болгох	-	-	Д.Зоригт, С.Баярцогт
13.4. Ядуурлыг тодорхойлох аргачлалыг шинэчлэн боловсруулж, ядуурлын зураглал гаргах бэлтгэлийг ханган, мэдээллийн сангийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Ганди, С.Мэндсайхан
13.4.1. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа 2002-2003, Хүн ам орон сууцны тооллого /2000 он/-д үндэслэн ядуурлын зураглалыг гаргах	-	Ядуурлын зураглал гарсан байна	Т.Ганди, С.Мэндсайхан
13.4.2. Өрх, хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлж байгаа аргачлалыг боловсронгуй болгон, амьжиргааны түвшин, хэрэгцээг судлах цогц аргачлалыг боловсруулж баталгаажуулах	-	-	Т.Ганди

13.4.3. Амьжиргааны түвшнээр ангилсан хүн амын мэдээллийн сан байгуулах ажлыг эхлүүлэх	-	-	Т.Ганди
<p>13.5. Ажлын байр шинээр бий болгох замаар хүн амын ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх</p> <p>13.5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах иргэдийн хүрээг өргөтгөх</p> <p>13.5.2. Гадаадаас авах ажиллах хүчний тоог багасгах, зам, барилга, уул уурхайн салбар дахь үндэсний мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэх зорилгоор үйлдвэрлэл дээрх сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</p> <p>13.5.3. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох арга хэмжээг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаатай уялдуулах “Ногоон ажлын байр” хөтөлбөр хэрэгжүүлэх</p> <p>13.5.4. “Нэг өрх-нэг ажлын байр” хөтөлбөр хэрэгжүүлэх замаар өрхийн амьжиргааг дэмжих</p> <p>13.5.5. Малчид, газар тариаланчдын хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авах</p>	<p>ажил эрхлэлтийн түвшин /хувиар/</p> <p>ажлын байр шинээр бий болгох /мян.хүн/</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>63.0</p> <p>60.0 мянгаас доошгүй</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Т.Ганди</p> <p>Т.Ганди</p>
<p>13.6. Хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс нийгмийн эмзэг бүлгийнхэнд очиж буй дарамтыг бууруулж, тэдэнд дэмжлэг үзүүлэх</p> <p>13.6.1. “Нийгмийн эмзэг бүлгийн зарим хэсэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулах</p> <p>13.6.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг Азийн хөгжлийн банкттай буцалтгүй тусламжийн гэрээ хийх замаар хэрэгжүүлж, төсөл хэрэгжүүлэх нэгж болон хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийг ажиллуулж эхлэх</p> <p>13.6.3. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 0-18 насны бүрэн хараагүй, сэтгэцийн өвчтэй хүүхэд, ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настныг нэн тэргүүнд хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт хамруулах</p>	<p>дэмжлэгт хамрагдах хүний тоо /мянга/</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>90.0 хүртэл</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Т.Ганди, С.Баярцогт</p> <p>Т.Ганди С.Баярцогт,</p> <p>Т.Ганди</p> <p>Т.Ганди</p>
13.7. Салбарын хөдөлмөрийн үнэлэмж, төвөөс алслагдсан байдал зэргийг харгалзан, инфляцийн зорилтот түвшинд хүрсний дараа үнэ, тарифыг хөөрөгдөхгүй байхаар төрийн албан хаагчдын цалинг төсвийн ерөнхийлөн	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Ганди

захирагч нартай зөвшилцөн нэмэгдүүлэх			
13.8. Өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Ганди, С.Баярцогт
13.8.1. Өндөр насны тэтгэврийн хэмжээг 30 хүртэл хувиар нэмэгдүүлэх, тэтгэвэр тооцох цалингийн дээд хэмжээг шинэчлэн тогтоох	-	-	Т.Ганди, С.Баярцогт
13.8.2. Тэтгэврийн хэмжээг инфляцийн бодит түвшинтэй уялдуулан өсгөх арга хэмжээ авах	-	-	Т.Ганди
13.9. Халамжийн үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх үйлчилгээний стандарт боловсруулж, гэрээлэх нөхцөл бүрдүүлэх	стандартууд туршигдсан байх	-	
13.9.1. Аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагаас халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар болон үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийн тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал, зааврыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар батлуулах	-	-	Т.Ганди
13.9.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээний стандарт батлуулан, мөрдүүлэх	-	-	
13.9.3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдэд нийгмийн халамж, асрамж, сувиллын үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулж, ажил үйлчилгээг гүйцэтгүүлэх	-	-	
13.10. Хүн амын насжих хандлагыг угтан ахмадын амьдралын чанар, эрүүл мэнд, тэтгэвэрт гарах үеийн болон гарсны дараа нийгэмд идэвхтэй байр сууриа хадгалах зэрэг асуудлыг цогцоор авч үзсэн насжилтын стратеги боловсруулах	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Ганди
13.10.1. Насжилтын стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг бүрдүүлэх асуудлаар олон улсын байгууллагатай хамтран төсөл боловсруулах	-	-	
13.11. Хүн амын хөгжлийн идэвхтэй үеийг ашиглах эдийн засаг, нийгмийн төлөвлөлттэй уялдуулах зорилгоор хүн амын хөгжил хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	хөтөлбөр батлагдсан байх	-	Т.Ганди
13.12. Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачилгад тулгуурлан өрхийн хөгжлийн	хөтөлбөр батлагдсан	-	Т.Ганди

<p>үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</p> <p>13.12.1. Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачилгад тулгуурлан “Өрхийн хөгжлийн Үндэсний хөтөлбөр” боловсруулах</p> <p>13.12.2. Хөтөлбөрийн хүрээнд өрх бүртэй тэдний боломж, хэрэгцээ, чадавхи, санаачилгад тулгуурласан “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулах арга хэмжээг зохион байгуулах</p>	байх		Т.Ганди
<p>13.13. Өрхийн аж ахуйг дэмжин, жижиг зээлийн үйлчилгээг өргөжүүлж, хөдөө орон нутаг, сумдад хүргэх</p>	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн эх үүсвэр /тэрбум төгрөг/	3.7	Т.Ганди, Т.Бадамжунай
<p>13.14. Иргэдийн нэрийн дансны мөнгийг баталгаажуулах, тэдний нийгмийн даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод болгох арга хэмжээг хэрэгжүүлэх</p> <p>13.14.1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны хуримтлалд Засгийн газар баталгаа гаргах асуудлыг УИХ-аар шийдвэрлүүлэх, нэрийн данснаас тэтгэвэр тогтоолгох итгэлийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээг авах</p> <p>3.14.2. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны хүү тооцох аргачлалыг боловсронгуй болгох эрх зүйн орчинг шинэчлэх</p> <p>13.14.3. Нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах үүднээс олон нийттэй харилцах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах, нэрийн дансанд бүртгэгдсэн хөрөнгө, Засгийн газраас тэтгэврийн санд нөхөн төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг нийтэд ил тод мэдээлэх</p> <p>13.14.4. Даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүгээр өссөн орлогын хэмжээ, нэрийн дансны үлдэгдлийг тусгасан “Нэрийн дансны мэдээлэх хуудас”-ыг ажил олгогч, даатгуулагчдад мэдээлэх, онлайн бүртгэлийн лавлагааны бааз бий болгох</p>	үйл ажиллагааны хэрэгжилтээр		Т.Ганди
<p>13.15. Малчин бүрийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалтай болгох ажлыг эхлүүлэх</p> <p>13.15.1. Малчдыг нийгмийн даатгалд хамруулахын тулд шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, орлого, шимтгэлийн хувь хэмжээг ялгавартай тогтоох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар судалж оновчтой хувилбарыг тодорхойлох, эрх зүйн орчинг нь бий болгох</p>			Т.Ганди

13.15.2. Малчдыг бүх нийтийн тэтгэвэрт хамруулах асуудлыг судалж Засгийн газраар хэлэлцүүлэх тэдэнд төрөөс тусгай тэтгэвэр олгох талаар санал боловсруулах	-	-	Т.Ганди
13.16. Нийгмийн хамгааллын бүртгэлийн тогтолцоог бий болгох	нийгмийн хамгааллын дугаарын сүлжээ бүрдэнэ	-	Т.Ганди
13.16.1. Тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн ажиллуулж эхлэх, холбогдох ажилтнуудыг сургалтад хамруулах	-	-	
13.17. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн сургалтын төвийг олон улсын жишигт нийцсэн үйлчилгээний шинэ төв болгон өргөтгөх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Т.Ганди
13.17.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсролын тусгай орчинг бүрдүүлэх, Мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн үйл ажиллагааг сайжруулж, мэргэжлийн боловсрол эзэмшилтийн хувь хэмжээг 30-40 хувиар нэмэгдүүлэх	-	-	
13.17.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн сургалтын төвийн барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зохицсон дэд бүтэц бүхий сэргээн засах эмчилгээ үйлчилгээний загвар төв болгох ажлыг эхлүүлэх	-	-	
13.18. Мянганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих мэдээллийн төрөлжсөн болон тусгай санг улс, аймаг, нийслэлийн түвшинд холбогдох мэдээллээр бүрдүүлэх	мэдээллийн сан бүрдсэн байх	үзүүлэлт бүрийг 2008 оны мэдээллээр байгуулах	С.Баярцогт, Т.Ганди, Засгийн газрын гишүүд
Зорилт 14. Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж эхэлсэнтэй холбогдуулан бүх шатны боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлнэ			
14.1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын агуулга, хөтөлбөрийг сайжруулах	сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт /хувь/	60.0	Ё.Отгонбаяр
14.1.1. Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт зохион байгуулах журам боловсруулж, батлуулах	-	-	
14.1.2. Бага насны хүүхдийг хөгжүүлэх хувилбарт сургалтын хөтөлбөр боловсруулах	-	-	

14.1.3. Хувилбарт сургалтын хөтөлбөрийн үзүүлэн боловсруулж, хэвлүүлэх, түгээх	-	-	Ё.Отгонбаяр
14.1.4. Хувилбарт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүүхдэд зориулсан дасгал ажлын дэвтэр боловсруулж, хэвлэх, түгээх	-	-	
14.2. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэх	хамрагдах анги	1-5	Ё.Отгонбаяр
14.2.1. Ерөнхий боловсролын сургуулийн цайны газарт тавигдах шаардлагыг боловсруулж мөрдүүлэх	-	-	
14.2.2. “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн мөрдүүлэх	-	-	
14.3. Ерөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх	6 настай хүүхдийн хамран сургалт /хувиар/ 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх анги, бүлэг	95.0 2 болон 7 дугаар анги	Ё.Отгонбаяр
14.3.1. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 2, шилжилтийн 7 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх	-	-	
14.3.2. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 3, 8 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийг туршиж эхлэх	-	-	
14.3.3. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн шилжилтийн 7 дугаар ангийн сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах арга зүйн зөвлөмжийг боловсруулах	-	-	
14.4. Ерөнхий боловсролын сургуульд түүх, соёлоо дээдлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	-	
14.4.1. “Эх оронч үзэл төлөвшүүлэх Үндэсний хөтөлбөр” боловсруулж батлуулах	-	-	Ё.Отгонбаяр
14.4.2. Суралцагчдын нас, сэтгэхүй, бие бялдрын онцлогт нийцүүлэн сум, аймаг, улс орноороо аялах аялалын аюулгүй байдлыг хангасан маршрутыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж	-	-	

хэрэгжүүлэх 14.4.3. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг, эх орны сэдэвт төрөл бүрийн уралдаан зохион байгуулах	-	-	Ё.Отгонбаяр
14.5. Ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжээр хичээллэдэг байдлыг багасгаж, сурагчдын дотуур байрны хүрэлцээг нэмэгдүүлэх	-	-	Ё.Отгонбаяр
14.5.1. Ээлжийн коэффициент өндөртэй орон нутагт шинээр ерөнхий боловсролын сургууль ашиглалтад оруулах	шинээр нэмэгдэх суудлын тоо	6000	Ё.Отгонбаяр
14.6. Хөдөөгийн сургуулийн дотуур байрны хангамжийг нэмэгдүүлэх	шинээр нэмэгдэх дотуур байрны орны тоо	600-гаас доошгүй	Ё.Отгонбаяр
14.6.1. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тавилга, хэрэгслийн хангамжийг сайжруулах арга хэмжээ авах	-	-	Ё.Отгонбаяр
14.6.2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны стандартыг боловсруулж мөрдүүлэх	-	-	Ё.Отгонбаяр
14.6.3. Дотуур байрны багшид зориулсан сургалт зохион байгуулах	-	-	Ё.Отгонбаяр
14.7. “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо /мян/	20.0	Ё.Отгонбаяр
14.7.1. Хөтөлбөрийн дагуу сургалтад ашиглах вэб сайтыг ашиглаж эхлэх	-	-	Ё.Отгонбаяр
14.7.2. Сургалтын электрон агуулгыг вэб сайтад байршуулан, багш, сурагчид ашиглах боломжийг бүрдүүлэх	-	-	Ё.Отгонбаяр
14.8. Ерөнхий боловсролын сургуулийг интернэтэд холбох ажлыг эрчимжүүлэх	цахилгааны байнгын эх үүсвэртэй сумдын тоогоор	-	Ё.Отгонбаяр
14.8.1. Ерөнхий боловсролын сургуулиудыг интернэтэд холбох боломжийг судлан, эхний ээлжинд интернэтэд холбох сургуулиудын жагсаалтыг гаргах	-	-	Ё.Отгонбаяр
14.8.2. Интернэтэд холбогдох боломжтой сургуулиудыг холбох ажлыг эхлүүлж, интернэтийн зардлыг олгож эхлэх	-	-	Ё.Отгонбаяр
14.9. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн баримжаа олгох сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгох	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ё.Отгонбаяр
14.9.1. Ерөнхий боловсролын 10-12 дугаар ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр, зөвлөмжийг боловсруулж	-	-	Ё.Отгонбаяр

мөрдүүлэх			
<p>14.10. Англи хэлний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх</p> <p>14.10.1. Англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, дээд боловсрол эзэмшигчдийг ажил, мэргэжлийнхээ чиглэлээр шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашиглах чадвартай болгох арга хэмжээ авч эхлэх</p> <p>14.10.2. Англи хэлний багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалт болон гадаадын сайн дурын англи хэлний багшийн тоог нэмэгдүүлэх</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр</p>
<p>14.11. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандартыг шинэчлэн боловсруулах</p>	<p>стандарт батлагдсан байна</p>	<p>-</p>	<p>Ё.Отгонбаяр</p>
<p>14.12. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сурагчдын сурлагын амжилтыг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх</p> <p>14.12.1. Бага, дунд боловсролын чанарын үнэлгээний талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, холбогдох журам боловсруулж мөрдүүлэх</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр</p>
<p>14.13. Зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хөдөлмөрийн захын эрэлт хэрэгцээний мэдээллийн системийг бүрдүүлэх</p> <p>14.13.1. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг чанаржуулж, эрэлт, нийлүүлэлтийн системийг ашиглалтад оруулан, мэргэжилтэй ажилтан бэлтгэх төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах</p>	<p>мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд элсэгчдийн өсөлт /хувиар/</p> <p>-</p>	<p>40.0</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр, Т.Ганди</p>
<p>14.14. Өрх бүрээс мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн нэгээс доошгүй хүнийг мэргэшүүлж ажилтай болгох асуудлыг эхлүүлэх</p> <p>14.14.1. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, техникийн боловсролын сургуулийн суралцагчдын тоог нэмэгдүүлэх</p>	<p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр, Т.Ганди</p> <p>Ё.Отгонбаяр</p>
<p>14.15. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг мэргэжлийн болон мастер багшаар бүрэн хангаж, “Атрын гурав дахь аян”-ы хэрэгжилттэй холбогдуулан газар тариалангийн мэргэшсэн ажилтан бэлтгэхийг дэмжих</p> <p>14.15.1. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багшийн хэрэгцээг гаргаж, мэргэжлийн болон мастер багшаар хангах арга хэмжээ авах</p> <p>14.15.2. Газар тариалангийн мэргэшсэн ажилтан бэлтгэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр, Т.Ганди, Т.Бадамжунай</p> <p>Ё.Отгонбаяр</p> <p>Т.Бадамжунай</p>

14.15.3. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нарыг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх сургалтад бүрэн хамруулж, тэдний цалин, нийгмийн баталгааг ахиулах	-	-	Ё.Отгонбаяр, Т.Ганди
14.16. Өмнөговь аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн салбар сургууль болгон өргөтгөх 14.16.1. Орон нутгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хэрхэн хангаж буйг судлан дүгнэлт гаргаж, орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Төрийн өмчийн хорооны шийдвэр болон Засгийн газрын шийдвэр гаргах санал боловсруулах	-	-	Ё.Отгонбаяр, Аймгийн Засаг дарга нар
14.17. Инженер, технологийн чиглэлээр нарийн мэргэшлийн мэргэжилтэн бэлтгэхийг нэмэгдүүлж, дотоодын их, дээд сургууль төгсөөд ажиллаж байгаа инженер, техникийн ажилтан, эмч нарыг төрийн зардлаар гадаадын нэр хүнд бүхий их, дээд сургуульд давтан сургаж мэргэшүүлэх 14.17.1. Инженер, технологи, байгалийн шинжлэл, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн мэргэжлээр элсэн суралцагчдын тоог нэмэгдүүлэх	инженер, технологийн мэргэжлээр элсэгчдийн өсөлт /хувиар/ гадаадад давтан сургах хүний тоо -	25.0 250-иас доошгүй -	Ё.Отгонбаяр
14.18. Дотоодын их, дээд сургуульд суралцахаар зохих журмын дагуу элсэж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргын захиалгаар албан ёсны гэрээ байгуулсан оюутны сургалтын зардлыг төрөөс хариуцах механизм бий болгож, 2009-2010 оны хичээлийн жилээс мөрдөх 14.18.1. Орон нутгийн захиалгаар онцгой шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнээр хангах журмыг батлан хэрэгжүүлж эхлэх	суралцах оюутны тоо -	50 хүртэл -	Ё.Отгонбаяр
14.19. Засгийн газраас шаардлагатай мэргэжлийн жагсаалт, ангилал, тоог жил бүр зарлаж, сургалтын төрийн сангаас үзүүлж буй зээл, тусламжийг тодорхой шалгуур хангасан суралцагчдад олгодог байхаар холбогдох журмыг өөрчлөх 14.19.1. Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг сурлагын амжилттай нь уялдуулан сургалтын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, тэтгэлэг олгох зэргээр оюутны сурах боломжийг төрөөс дэмжих	-	-	Ё.Отгонбаяр

<p>14.20. Хотын хэт төвлөрлийг сааруулах, шинжлэх ухааны чадавхийг дээшлүүлэх ажлын хүрээнд шинжлэх ухаан, технологи, чанартай боловсролын нээлттэй бүс буюу их, дээд сургуулийн хотхоныг хотын төвөөс зайдуу газарт барьж байгуулах ажлыг дэмжиж, бэлтгэл ажлыг эхлүүлэх</p> <p>14.20.1. Их сургуулийн хотхон байгуулах үзэл баримтлалыг батлуулж, хотхон байгуулах ажлыг зохион байгуулах</p> <p>14.20.2. Геологи, уул уурхайн чиглэлийн дээд болон мэргэжлийн боловсролын сургуулийн хотхоныг Эрдэнэт хотод байгуулах хөрөнгө оруулагчийг тодруулах</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр</p>
<p>14.21. Шинжлэх ухаан, технологи, инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэн тодорхойлж, технологийн хөгжлийн чиг хандлагыг үйлдвэрлэлтэй уялдуулан хөгжүүлэх</p> <p>14.21.1. Шинжлэх ухаан, технологи, инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх</p> <p>14.21.2. Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх улсын захиалгатай хөтөлбөр, төслийг үйлдвэрлэлийн хэрэгцээтэй уялдуулах зохицуулалт хийх</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр</p>
<p>14.22. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх</p> <p>14.22.1. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор гүйцэтгэх зохицуулалтыг шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журамд нэмж тусгах</p> <p>14.22.2. Хувийн хэвшлийн оролцоотой гүйцэтгэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын хувийн жинг нэмэгдүүлж, нэвтрүүлэх зэхэц ажлыг нэмэгдүүлэх</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр</p>
<p>14.23. Өөрийн орны хөгжлийн онцлогт тохирсон үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх</p> <p>14.23.1. Инноваци, инновацийн сангийн талаар хуулийн төсөл боловсруулах</p> <p>14.23.2. Шинжлэх ухаан, технологийн тухай, Технологи дамжуулах тухай хуулиудыг инновацийн чиглэлээр сайжруулан боловсруулах</p>	<p>холбогдох хууль батлагдана</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр</p>

<p>14.24. Биотехнологи, нанотехнологи зэрэг дэвшилтэт технологийн судалгаа, боловсруулалтыг нэмэгдүүлж, туршилт-сорилтын баазыг бэхжүүлэх</p> <p>14.24.1. Биотехнологи, нанотехнологийн чиглэлээр 50-иас доошгүй зорилтот хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх</p> <p>14.24.2. 2008 онд байгуулж эхэлсэн судалгааны зарим лабораторийг батлагдсан хөрөнгө оруулалтын хэмжээнд нэмж тоноглох</p>	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ё.Отгонбаяр
<p>14.25. Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн эрдэм шинжилгээний ажилтан, залуу судлаачдыг дотоод, гадаадад бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх</p> <p>14.25.1. 40-өөс доошгүй залуу судлаачийг англи хэлний эрчимжүүлсэн сургалтад хамруулах</p> <p>14.25.2. Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр 15-аас доошгүй судлаачийг өндөр хөгжилтэй оронд суралцуулах</p> <p>14.25.3. Нарийн мэргэшсэн эрдэм шинжилгээний 20-иос доошгүй ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх арга хэмжээ авах</p> <p>14.25.4. Инновацийн үйл ажиллагаанд оролцогч мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх давтан сургах тогтолцоог хөгжүүлэх</p> <p>14.25.5. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, Монгол Улсад олгосон гадаадын зээл, тусламжийн тодорхой хувийг эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, эрдэм шинжилгээний ажлын сорилт, туршилтын баазыг бэхжүүлэхэд зарцуулдаг болох</p>	суралцах хүний тоо	100 хүртэл	Ё.Отгонбаяр
<p>14.26. Соёлын өв уламжлалыг хадгалан хөгжүүлэх ажлын хүрээнд Соёлын тухай хуулийг боловсронгуй болгож, "Монгол Улсын соёл, урлагийг 2009-2016 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-г боловсруулж, хэрэгжүүлж эхлэх</p> <p>14.26.1. Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх</p>	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	Ё.Отгонбаяр

14.26.2. “Монгол Улсын соёл, урлагийг 2009-2016 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж эхлэх	-	-	
<p>14.27. Үндэсний уламжлалт соёлын өвөө хадгалж хамгаалах, сэргээн засварлах, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх</p> <p>14.27.1. Музейн сан хөмрөгийг баяжуулах зардлыг нэмэгдүүлж, хүүхэд, залуусын танин мэдэхүйг хөгжүүлэх, тэдэнд эх оронч үзэл, төлөвшүүлэхэд музей, боловсролын байгууллагын хамтын ажиллагааны үр өгөөжтэй түншлэлийг буй болгох</p> <p>14.27.2. Биет бус соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн хөгжүүлэх, өв тээгчийг тогтоох, бүртгэх, төрөөс дэмжих арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх</p> <p>14.27.3. Музейг орчин үеийн техник, тоног төхөөрөмж бүхий хамгаалалтын хэрэгслээр хангах, менежментийг нь боловсронгуй болгож улмаар түүх, соёлын үнэт зүйлс, музейн үзмэрийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр</p>
<p>14.28. Сумын соёлын төвийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг баяжуулж тогтмолжуулах, соёлын төвүүдийн барилгыг шинэчилж засварлах, хөгжмийн зэмсэг, ном, тоног төхөөрөмжөөр хангах замаар хүүхэд, залуучууд, хүн амд хүргэх соёлын үйлчилгээний нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэх</p> <p>14.28.1. Соёлын төвүүдийн барилгыг шинээр барих, их засвар хийх ажлыг дэс дараатайгаар хэрэгжүүлэх</p> <p>14.28.2. Мэргэжлийн урлагийн байгууллага музей, номын сан, соёлын төвийн техник тоног хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх</p> <p>14.28.3. Хүүхдэд зориулсан уран бүтээлийн төрөл, зүйлийг олшруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх</p> <p>14.28.4. Мэргэжлийн урлагийн байгууллагын шилдэг уран бүтээлийг хөдөөгийн иргэдэд хүргэх, соёлын үйлчилгээг төрөөс дэмжиж өргөжүүлэх</p>	<p>үйл ажиллагааны хэрэгжилтээр</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>Ё.Отгонбаяр</p>

Зорилт 15. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж, элдэв өвчлөлийг эрс бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хүн амын өсөлтийг дэмжихэд чиглүүлнэ			
15.1. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг шинэчилж, Монгол Улсын нутаг дэвсгэрийн алслагдсан аль ч газарт шаардлагатай үед цаг алдалгүй хүрч тусламж үзүүлэх “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ” байгуулах ажлыг эхлүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	
15.1.1. “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ” байгуулах асуудлыг судлан санал боловсруулах ажлын хэсэг байгуулах	-	-	С.Ламбаа
15.1.2. Нийслэлийн түргэн тусламжийн парк шинэчлэлтийг хийж, зарим дүүрэгт түргэн тусламжийн салбар байгуулах /Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг/	-	-	
15.1.3. Эмнэлэг хүртэлх яаралтай тусламжийн эмнэл зүйн удирдамж боловсруулах	-	-	
15.1.4. Аймаг бүрт 5-6 сумын дунд явуулын амбулаторийн үйлчилгээг байгуулж, тоноглогдсон тээврийн хэрэгслээр хангах ажлыг судлах, бэлтгэл ажлыг хангах	-	-	
15.2. Эрүүл мэндийн үйлчилгээнд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтуудыг нэвтрүүлж, улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зайны оношилгооны цахим эмнэлгийн нэгдсэн сүлжээ бий болгох	-	-	С.Ламбаа
15.2.1. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбох, мэдээлэл, технологийн мэргэжилтэн бэлтгэж хангах ажиллагааг судлан, хөрөнгө, санхүүгийн тооцоо хийх	-	-	
15.3. Эрүүл мэндийн үйлчилгээнд эрхийн бичгийн тогтолцоог нэвтрүүлж, иргэн бүрийг жилд нэг удаа эмнэлгийн иж бүрэн, нарийн мэргэжлийн цогц үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулж эхлүүлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	С.Ламбаа
15.3.1. Иргэн бүрийг жилд нэг удаа эмнэлгийн иж бүрэн, цогц үзлэг оношлогоонд хамруулах бодит нөөц боломжийг судлан хөрөнгө, санхүүгийн тооцоо хийх		-	

15.4. Иргэдийг эрүүл мэндийн орчин үеийн найдвартай, чанартай, хүртээмжтэй үйлчилгээнд хамруулахын тулд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг шинээр байгуулахыг дэмжиж, Улсын төв эмнэлгийн оношилгоо, эмчилгээний өргөтгөлийг шинээр барьж эхлэх	-	-	С.Ламбаа
15.5. Орхон аймагт оношилгооны төв байгуулах	-	-	С.Ламбаа
15.6. Малчин, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг нөхөн үржихүйн эм, хэрэгслээр тогтвортой хангах ажлыг үе шаттайгаар эхлүүлэх	нэн шаардлагатай эмийн хангалт /хувь/	85.0	
15.6.1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй тогтвортой хангамжийн үндэсний стратеги, түүний дагалдах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан мөрдөх	-	-	С.Ламбаа
15.6.2. Алслагдсан нутгийн хүн ам, ядуу иргэд, эмзэг бүлгийн хэрэгцээт нөхөн үржихүйн эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн тооцоог хийх	-	-	
15.7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналттай уялдуулан эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэх	үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	С.Ламбаа, Т.Ганди
15.7.1. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан нэгжийн чиг үүргийн хүрээнд даатгуулагчдад үзүүлэх эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний чанар үр дүнд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох	-	-	С.Ламбаа
15.7.2. Өвчин эмгэгийн оношилгоо эмчилгээний удирдамжийг өвчин тус бүрээр гаргаж түүний дагуу тусламж үйлчилгээний чанар үр дүнг хянах	-	-	
15.7.3. Эрүүл мэндийн байцаагчийн эрх үүргийг өргөтгөх замаар хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах	-	-	С.Ламбаа
15.7.4. Эрүүл мэндийн санхүүжилтийн бодлогыг боловсруулж, батлуулах	-	-	
15.7.5. Эрүүл мэндийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	-	-	

